224

# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 8 дугаар сарын 11 өдөр

Дугаар А/176

Улаанбаатар хот

**Хүүхдийн клиник сувилалын талаар авах зарим арга хэмжээний тухай**

Нэг. Бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, боловсон хүчин, байрны нөөц боломжийг бүрэн ашиглах, эмийн бус эмчилгээг өргөтгөх зорилгоор "Хүүхдийн клиник сувилалыг" архаг өвчтэй хүүхэд болон насанд хүрэгчдийг эмчлэн сувилах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үндсэн үүрэг бүхий "Сэргээн засах клиникийн эмнэлэг" болгон 1998 оны 8-р сарын 01-нээс эхлэн ажиллуулсугай.

Хоёр. Тус сувилалыг Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 3-р бүлгийн 12-р зүйл, Эрүүл мэндийн хуулийн 2-р бүлгийн 10-р зүйлийг үндэслэн энэ онд батлагдсан 120 орыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх арга хэмжээ авахыг нийслэлийн Эрүүл мэндийн газар /н.Тэрбиш/, нийслэлийн Нийгмийн даатгалын газар /н.Сумаахүү/ нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Нийслэлд Иргэний эрүүл мэндийн даатгалын сангаас 1998 онд санхүүжигдэж байгаа орны тооноос зохицуулалт хийхийг нийслэлийн Эрүүл мэндийн газар /н.Тэрбиш/-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ - г

Ж.НАРАНЦАЦРАЛТ